

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРААС 2020 ОНЫ НАЙМДУГААР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 09 дүгээр сарын 01

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2020 оны 08 дугаар сарын 01-ээс 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 16 орны 30 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон ба түр ирэгчийн бүртгэл 7, хасалт 27, оршин суух зөвшөөрлийн хасалт 20 хийсэн байна.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Тайлант хугацаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгатыг зохион байгуулаагүй. Системээр давхардсан тоогоор 35 орны 457 гадаадын иргэний мэдээллийг шүүж шалгасан ба зөрчил илрээгүй байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэлтийн талаар:

Тайлангийн хугацаанд гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг нэг хоног хэтрүүлсэн 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 10,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд нийт 5 орны 5 гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагааг гүйцэтгэж албадан гаргасан тухай тодорхойлолтыг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд орох виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн үндэслэлээр улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэн байхгүй болно. Мөн гарах-орох визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй, торгууль төлөх чадваргүй /мөнгөгүй/ зэрэг үндэслэлээр Монгол Улсын хилээр гаргаагүй гадаадын иргэн байхгүй болно.

Шүүх, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1.6. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Тайлант хугацаанд ярилцлага хийгдээгүй болно.

1.7. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэн байхгүй байна.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 1 /хүний нөөцтэй холбоотой 1/ тушаал батлан гаргаж биелэлтийг тооцов.

Тус газрын 2020 оны 8 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлтийг хангаж ажилласан.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүлээ:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлт, өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж тогтоосон хугацаанд Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст;

2.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Тайлант хугацаанд архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Бичиг хэрэгт 7 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 1 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 4 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан тушаал, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж байгаа 25 албан хаагч байна. Үүнээс ээлжийн амралттай 3, декреттэй 3, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч байна.

Төрийн албаны зөвлөлийн цахим програмд 2020 оны 8 дугаар сард албан хаагчдад олгосон нэмэгдэл /24 албан хаагчийн нийтийн тээвэр, хоолны хөнгөлөлт, байгууллагын даргын 2020 оны Б/220 дугаар “Зарим албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” тушаалын дагуу 3 албан хаагчийн төрийн алба хаасан хугацаа/-ийг 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдөр оруулсан болно.

Ёс зүйн хариуцлагын талонд арга хэмжээ авахуулсан албан хаагч байхгүй.

Захиргаа, удирдлагын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу тус газрын албан хаагчийн анкет, судалгааг шинэчлэн гаргаж хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд тус газраас сургалт зохион байгуулаагүй. 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдөр “Нью Улаанбаатар Интернэшнл Эйрпорт” ХХК-иас зохион байгуулсан “Чингис хаан” олон улсын нисэх буудалд гарсан “Агаарын хөлгийн осол” сэдэвт урьдчилсан дасгал сургуулилтад 1 албан хаагч хамрагдсан.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсөв болох 460,607,400 төгрөгийн санхүүжилт орсноос цалин хөлсөнд 339,264,900 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 67,728,504 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 20,720,905 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2020.08.05-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 59,970,791 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2020.08.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 399,540,100 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 327,197,039 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Албан хаагчдад шийтгэлийн хуудас 49, визийн хуудас олгоогүй. Өссөн дүнгээр хүү торгууль 22,080,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж 29,368,890 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 1,812,314 төгрөг, байрны түрээс 23,586,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно.

Түлш шатах тослох материалд 10.417.900 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан.

Бараа материалд 6,134,133 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.

Тус газрын албан нийгмийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд сүлжээ болон техник хэрэгслийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангаж ажилласан бөгөөд тус газрын нисэх буудал дээр байрлах ирэх, явах чиглэлийн, хяналтын улсын ахлах байцаагч, захиргааны ахлах мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч нарын ажлын компьютерийг форматлаж шаардлагатай хэрэглээний програмыг суулгаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Газраас товлогдсон мэдээллийн цагаар онлайн хурлын төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд 2020 оны 7 дугаар сард хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл, гомдлын мэдээ, 8 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө болон шилэн дансанд холбогдох мэдээллийг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчилах танин мэдүүлэх зорилгоор биечлэн 36, утсаар 26 иргэнд зөвөлгөө мэдээлэл өгсөн байна.

Дөрөв. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний талаар

Тус газрын албан хаагчид 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр “Чингис Хаан” нисэх буудалд байрлах албан хаагчдын амралтын өрөө, ирэх, явах чиглэлийн ажлын өрөөнүүдийн тохижилт, тавилга угсалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.



Тав. Бусад

Ээлжийн ахлахууд “Чингис Хаан” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчийн 10:00 цагийн шуурхай хуралд тогтмол сууж хил хяналтын бусад байгууллагуудтай мэдээлэл солилцон хамран ажилласан байна.

Төв газраас 2020 оны 8 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулсан цахим хуралд тус газрын 17 албан хаагч хамрагдаж байгууллагын удирдлагаас үүрэг, чиглэл авав.

2020 оны 8 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан Агаарын тээврийг хялбаршуулах хорооны хуралд тус газрын дарга, виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн нар хамрагдаж өндөржүүлсэн бэлэн байдал цуцлагдаж олон улсын нислэгийг сэргээх үед нисэх буудлын зүгээс авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, агаарын тээвэрлэгчийн зүгээс авах арга хэмжээ, холбогдох байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв.

Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооноос зохион байгуулсан тус хороонд оршин суудаг, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтод бүлгийн өрхийн амьжиргааг дэмжих “Хичээлийн шинэ жил-Хамтдаа угтая” өдөрлөгт тус газрын албан хаагчид хамрагдаж 2 хүүхдэд хичээлийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслэлийг бэлтгэн өгсөн.

